

Журам батлах тухай

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Удирдлагын багийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталж, 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Тушаалыг удирдлагын багийн гишүүдэд танилцуулахыг Хүний нөөцийн алба (Ж.Өүлэндарь)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Т.Баярмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

3.2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийндугаар тушаалаар баталсан “Удирдлагын багийн ажиллах журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

4. “Удирдлагын багийн бүрэлдэхүүнийг томилох тухай” 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/01 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ

Ц.УРАНЧИМЭГ

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын 2024 оны дугаар сарын-ний
өдрийн дугаар тушаалын хавсралт

АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН УДИРДЛАГЫН БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Арьсны Өвчин Судлалын Үндэсний Төвийн Удирдлагын баг /цаашид Удирдлагын баг гэх/ үйл ажиллагаандаа энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана. Удирдлагын багийн гишүүд Төвийн захиралд санал гаргаж зөвлөх эрхтэй оролцох ба төвийн дотоод асуудал болон захирал хэлэлцүүлэхээр оруулсан асуудлыг хэлэлцэж хамтын шийдвэр гаргана. Санал тэнцсэн тохиолдолд шийдвэрийг Төвийн захирал гаргана.

1.2. Удирдлагын баг эмнэлгийн үйл ажиллагааг бүхэлд нь үр дүнтэй, үр ашигтай ажиллуулах, эмнэлгийн чиг үүргийн гүйцэтгэлийг сайжруулах, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг тасралтгүй сайжруулахад үйл ажиллагаа нь чиглэх бөгөөд байгууллагын удирдах албан тушаалтан оролцсон дараах 7-9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Удирдлагын багийн дарга: -Захирал

Нарийн бичгийн дарга: -Хүний нөөцийн албаны дарга

Гишүүд: -Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал

-Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал

-Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албаны дарга

-Санхүүгийн албаны дарга, Сувилахуйн албаны дарга

-Аж ахуйн албаны дарга

-Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга тус тус орно.

Хоёр. Удирдлагын багийн хурлын зохион байгуулалт

2.1.Удирдлагын багийн гишүүдийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байх бөгөөд тодорхой асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах эрхтэй.

2.2.Хурлаар хэлэлцэх асуудлыг хурлын нарийн бичгийн дарга /Хүний нөөцийн албаны дарга/ Төвийн захиралд урьдчилан танилцуулан бусад гишүүдэд мэдэгдэх ба бэлтгэлийг хангана.

2.3.Хэлэлцэх асуудал дэвшүүлсэн гишүүн болон бусад гишүүд хуралд асуудалтай холбоотой бэлтгэлийг бүрэн хангаж танилцуулна.

Гурав. Удирдлагын багийн хурлын дэг

3.1.Хурлыг сар бүр тогтмол хийх бөгөөд удирдлагын багийн даргын шийдвэрээр хойшлуулах, эсхүл шаардлагатай тохиолдолд буюу цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан шуурхай хурал зарлан хуралдана.

3.2.Багийн нийт гишүүдийн 80% ирснээр хурал эхлэх ба асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3.3.Захирлын эзгүйд зайлшгүй шаардлагаар хуралдах тохиолдолд Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал хурлыг удирдана.

3.4.Хурал нь хэлэлцэх асуудлыг танилцуулах, асуулт, хариулт, санал, дүгнэлт, шийдвэр гаргах гэсэн дараалалтай байна.

3.5.Хурлаар хэлэлцэх асуудлыг тэмдэглэлд тэмдэглэх бөгөөд тэмдэглэлд хурал эхэлсэн хугацаа, дууссан хугацаа, ирц, хэлэлцсэн асуудал, онцолсон заалт, асуулт, хариулт, санал, дүгнэлт, шийдвэр зэргийг тусгана.

3.6.Багийн гишүүн бүр тусгай дэвтэрт тэмдэглэл хийх ба нарийн бичгийн дарга тухайн хурал дээр олгож, буцаан авна.

3.7.Хурлаар хэлэлцсэн асуудлаар эцсийн шийдвэрийг Захирал гаргаж танилцуулна.

Дөрөв. Удирдлагын багийн гишүүдийн үүрэг

4.1.Удирдлагын багийн гишүүд дараах үүрэгтэй. Үүнд:

4.1.1.Удирдлагын багийн гишүүд эмнэлгийн зорилго, зорилт хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, өртөг зардлыг бууруулах, оношилгоо эмчилгээний эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд шаардлагатай сайжруулалтад чиглэсэн тодорхой арга хэмжээ авах;

- 4.1.2.Эмнэлгийн төсвийг үр ашигтай захиран зарцуулах;
- 4.1.3.Нөөцийг оновчтой хуваарилах;
- 4.1.4.Эрүүл ахуйн хэм хэмжээ халдвараас сэргийлэх дэглэм хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимыг мөрдөж ажиллах;
- 4.1.5.Хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;
- 4.1.6.Нийтэд мэдээлэхэд хамаарахгүй, байгууллагын болон хувь хүний нууцтай холбоотой асуудлын нууцыг чандлан хадгалах;
- 4.1.7.Тогтоосон болон зарласан хугацаанд хуралд хоцрохгүй хүрэлцэн ирж идэвхтэй оролцох;
- 4.1.8.Хэлэлцэж байгаа асуудалд ёс зүйтэй, хууль зүйн үндэслэлтэй хандах, мэргэжлийн ёс зүйтэй хуралд оролцож, хурлын дэгийг нарийн баримтлах;
- 4.1.9.Хэлэлцэж буй асуудалд ашиг сонирхлын зөрчилгүйгээр хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт гаргах;
- 4.1.10.Гишүүд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд хурлын нарийн бичгийн даргад энэ талаар хурлын өмнөх өдөрт багтаан мэдэгдэнэ.

Тав. Удирдлагын багийн гишүүдийн эрх

- 5.1. Удирдлагын багийн гишүүд дараах эрхтэй. Үүнд:
 - 5.1.1.Хэлэлцэж буй асуудлаар асуулт асуух хариулт авах өгөх тайлбар санал дүгнэлт гаргах;
 - 5.1.2.Удирдлагын багийн гишүүд байгууллага хамт олны хууль ёсны эрх ашгийн талаар саналаа чөлөөтэй илэрхийлэх;
 - 5.1.3.Хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих.

* * *
